

**2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН ЯВЦЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭЖ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2024.05.10

Шивээговь сум

Д/д	Зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт	Хувь
1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх	1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт “Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо-2 Нөхцөл байдлын үнэлгээг хийсэн байх Хамтарсан багийн төлөвлөгөөний хэрэгжилт-100%	01-11 сард	<p>“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ <b>Хамтарсан багийн 2024 оны ажлын төлөвлөгөөг</b> 1 зорилт 10 арга хэмжээтэйгээр төлөвлөж, 7 ажлыг хийж гүйцэтгэн төлөвлөгөөний гүйцэтгэл 70%-тай.</li> <li>➢ <b>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор</b> сумын Ерөнхий боловсролын суралцагчдад болон эцэг эхэд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн товч танилцуулга, гэр бүлийн хүчирхийллээс урьдчлан сэргийлэх чиглэлээр 2024 оны 2 дугаар сарын 15, 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрүүдэд 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад давхардсан тоогоор 456 эцэг эх, 324 хүүхэд оролцсон.</li> <li>➢ Сумын Эрүүл мэндийн төв, 3-р сургууль болон Цагдаагийн хэсэг нар хамтран 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр 8-11 дүгээр ангийн суралцагчдын дунд архи тамхи, мансууруулах бодис, <b>гэр бүлийн хараа хяналт, гэр бүлийн хүчирхийллийн талаарх сургалтыг</b> нийт 115 суралцагчдад зохион байгуулаад байна.</li> <li>➢ 2024 он гарснаар хүүхдийн тусламжийн 108 дуудлага мэдээлэлд 03 дугаар сарын 04, 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд 2 дуудлага мэдээлэл ирсэн бөгөөд тус дуудлага мэдээллүүдэд <b>нөхцөл байдлын үнэлгээ</b> хийж, арга хэмжээ авч ажиллаад байна.</li> </ul> <p><b>Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо-2</b> <b>Хамтарсан багийн төлөвлөгөөний хэрэгжилт-70%</b> <b>Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн тоо-2</b></p>	100

2	ҮАБЗөвлөлийн 2019 оны 60/40 дугаар зөвлөмжийн 2.4 дэх хэсгийг хэрэгжүүлэх	2	“Томоохон голууд дээр усыг хуримтлуулан ургацын тохируулга хийх. Усан сан байгуулах, нийт нутгийн хэмжээнд хур тунадасны усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэн цөөрөм барих ажлыг эрчимжүүлэх замаар усны нөөцийг нэмэгдүүлж, хүн ам болон эдийн засгийн салбаруудыг баталгаатай, хүрэлцээтэй усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх	Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоо Усан сан нэмэгдүүлэх Хүн амыг баталгаатай, хүрэлцээтэй усаар хангах	01-11 сард	Хаялага нуурыг түшиглэн сумын иргэд төмс, хүнсний ногоо тариалалдаг бөгөөд эргэлтийн талбайг услах чиглэлээр нуурын усыг ашиглаж байна. Ундны усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулахаар алсын 1, 2 худагт 2021 оны ОНХС-ийн 19,7 сая төгрөгийн хөрөнгөөр 6 камер байршуулан хяналт тавин ажиллаж байна. Мөн өргөх станц, зүүн гэр байр, урд гэр байрны худгуудаас улирал бүр дээж авч аймгийн лаборатороор шинжлүүлэн ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор Сумын ундны усны эх үүсвэр, автоматжуулалтын ажилд 380,000,000 төгрөгийг батлуулсан. Тус ажлын дагуу 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн А/18 дугаар захирамжаар “Үнэлгээний хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Техникийн тодорхойлолтыг батлуулж, нээлттэй тендерийг цахим сайтад зарласан. 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлгээний хороогоор ирүүлсэн материалыг хянаж үзээд, “Толгод констракшн” ХХК шалгарч 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна.	100
3	ЗГ-ын 2022 оны "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 419 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх	3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллах	ОНХС-аар хийгдэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт Тухайн ажлуудад хяналт тавьсан байдал	01-11 сард	2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөөнд 13 ажил төлөвлөгдсөн бөгөөд 10 ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулагдан батлагдаж нээлттэй тендер шалгаруулалтыг тогтмол цахимд зарлан ажиллаад байна. Тендер амжилттай болж, шалгарсан компаниудтай гэрээг байгуулан, тус ажлуудад <b>“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга” хуулийн</b> хэрэгжилтийг ханган ажиллаж, бусад холбогдох хууль дүрэм журмын дагуу тогтмол хяналт тавин ажиллаж байна. ОНХС-аар хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилээр гүйцэтгэл 30%-д хүргэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 44%-тай буюу төлөвлөгөөнөөс давсан үзүүлэлттэй байна.	100
			ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй		Уул уурхайн үйлдвэрлэл, тээвэрлэлт эрхэлдэг, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг 3 аж ахуй нэгжүүдтэй хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хариуцлагын хүрээнд:	

		4	захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулах	байгуулсан гэрээний тоо Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын тоо	01-11 сард	2024 он гарснаар сумын хэмжээнд өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбоотой сэг зэм устгалын ажил, цасанд боогдсон газруудаар зам гаргах, малчин өрхүүдэд өвс тэжээл тээвэрлэх, тараах ажилд хүн хүч, машин техник бараа материалаар туслалцаа үзүүлэн ажиллаад байна. <ul style="list-style-type: none"> <li>➢ “Шивээ-Овоо” ХК сэг зэм цуглуулах, зөөх, булж устгах ажилд <b>5 удаа</b>,</li> <li>➢ “МАК” ХК зам гаргах, сэг зэм цуглуулж зөөж, булж устгах ажилд <b>12 удаа</b>,</li> <li>➢ “Страто” ХХК зам гаргах, сэг зэмийн ажилд <b>7 удаа</b> тус тус явж ажилласан байна.</li> </ul> Мөн “Эйкү сора” ХХК, “Цотан жанжин транс” ХХК-ууд нийгмийн хариуцлагын хүрээнд сумын малчдад өвс тэжээл тараах ажлыг 2 удаа гүйцэтгээд байна.	100
		5	нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэх	Нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн тоо Хүсэлтийг нь шийдвэрлэсэн байдал	01-11 сард	2024 оны хагас жилийн байдлаар нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуй нэгж болон тус ААН нь газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгож өгөх хүсэлт ирүүлсэн санал ирээгүй байна.	-
4	ЗГ-ын 2022 оны 06 дугаар албан даалгавар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”	6	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиглагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харьяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах;	Сургалт зохион байгуулсан тоо Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	01-11 сард	2023 оны 03 дугаар сарын 22, 23-ны өдөр Аймгийн Онцгой байдлын газарт зохион байгуулагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын богино хугацааны танхимын сургалтад сумаас 10, аймаг нийт 100 төрийн албан хаагчид хамрагдаж, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Алсын хараа 2050”-ын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна. Тус сургалтад хамрагдсан төрийн албан хаагчид хамаарах байгууллагууд болох /ЗДТГ, ЕБС, 3-р цэцэрлэг, “Илчлэг Шивээ” ААТҮГ/-уудын албан хаагчдадаа 2024 оны 02 сард сургалтыг зохион байгуулаад байна. <b>Сургалт зохион байгуулсан тоо-4</b> <b>Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо-80 гаруй</b>	100

		7	<p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо Мэдээ мэдээлэл хүргэсэн байдал Хамрагдсан иргэдийн тоо</p>	01-11 сард	<p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд иргэдэд мэдээ мэдээллийг “Шивээговь сум мэдээ” хаягаар тогтмол хүргэж сум орон нутагт ирж сууршиж байгаа иргэд болон албан байгууллагуудад шинээр ирсэн албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хийлгэх ажлыг байгууллагын дарга нартай хамтран зохион байгуулан ажиллаж байна. 2024 он гарснаар суманд нийт 3654 иргэн амьдран, ажиллаж оршин сууж байгаагаар бүртгэгдсэн бөгөөд албан ёсоор орон нутгийн шилжүүлэг хийгдээгүй боловч хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласнаар 45 албан хаагч, тэдгээрийн хүүхэд 17, нийт 62 иргэн суманд шилжин ирээд байна. Шилжин ирсэн 45 иргэнийг салбараар нь ангилвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Ерөнхий боловсролын сургуульд 10,</li> <li>➢ “Шивээ-Овоо” ХК-д 15,</li> <li>➢ Сургуулийн өмнөх боловсролд 4,</li> <li>➢ Бусад байгууллагад 16 иргэн ажиллаж, шинээр шилжин ирээд байна.</li> </ul> <p><b>Хүн амын тоо-3654</b> <b>Шилжин ирсэн иргэдийн тоо-62</b></p>	100
5	<p>ЗГ-ын 2022 оны хуралдааны тэмдэглэл “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллах”</p>	8	<p>Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хэрэгжүүлсэн арга хэмжээ бодит үр дүнд хүрсэн байх</p>	01-11 сард	<p>Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд Нийтийн их цэвэрлэгээг 2024 он гарснаар <b>нийт 5 удаа</b> зохион байгуулаад байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Сумын Засаг даргын 2024 оны 1 дүгээр 10-ны 1/17 албан тоотын дагуу АБ, ААН-ууд өөрсийн хувиарт талбайг цэвэрлэх, тарьсан модоо цасаар хучих, мод бутан манах, хашааг засан янзлах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</li> <li>➢ 2 дугаар сарын 7-ны өдөр сумын 15 АБ, ААН-ын 45 албан хаагч оролцож, нийт 4.8 га талбайн 4 тн хог хаягдлыг зөөж тээвэрлэн төв хогийн цэгт буулгасан байна.</li> <li>➢ 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр 45 АБ, ААН, орон сууцны иргэд нийт 154 хүн Нийтийн их цэвэрлэгээнд оролцсон бөгөөд байгууллага бүр 50 метрт газар, хуваарьт талбайг цэвэрлэж, 5 га талбайн 6 тонн хог хаягдлыг тээвэрлэн төв хогийн цэгт буулгаж ажилласан.</li> </ul>	100

					<ul style="list-style-type: none"> <li>➤ 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр АБ, ААН-үүд өөрсдийн хуваарьт талбайн элс шороо, хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулан 5 АБ, ААН-ийн 20 хүн оролцсон бөгөөд 5 тонн элс, 1,5 тонн хог хаягдлыг цэвэрлэж ачиж ажилласан байна.</li> <li>➤ 2024 оны 05 дугаар сарын 15 АБ, ААН-ын ажилтан, албан хаагч 35, оршин суугч иргэд 30 нийт 60 орчим хүн оролцож, 6 га талбайн 5 тонн хог хаягдлыг цэвэрлээд байна.</li> </ul> <p><b>Зохион байгуулсан арга хэмжээний тоо-5</b></p>		
6	Засгийн газрын 2022 оны хуралдааны тэмдэглэл “Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагдыг хамруулах, ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авах”;	9	“Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагдыг хамруулах, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулах	Эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулсан тоо Хамрагдсан албан хаагчдын тоо	01-11 сард	<p>Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд төрийн бүх шатны байгууллагууд ажилтан, албан хаагчдаа хамруулдаг бөгөөд 2024 он гарснаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ <b>Засаг даргын Тамгын газар</b> 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр сумын Эрүүл мэндийн төвд 13 албан хаагчдыг;</li> <li>❖ <b>Соёлын төв</b> 2024 оны 03 дугаар сард Улаанбаатар хотын Хавдар судлалын үндэсний төвд 1 албан хаагчийг, 04 дүгээр сард аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2 албан хаагчийг;</li> <li>❖ <b>Эрүүл мэндийн төв</b> 2024 оны 03 дугаар сард Улаанбаатар хотын “Brilliant” эмнэлэгт 12 төрлийн шинжилгээгээр 20 албан хаагчдыг эрт илрүүлэг үзлэгт хамруулаад байна.</li> </ul> <p><b>Эрт илрүүлэг шинжилгээнд хамруулсан тоо-3</b> <b>Хамрагдсан албан хаагчдын тоо-36</b></p>	100
7	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	10	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалт "Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ" 8.5.2 дах заалт "тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хангаж ажиллах Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4.4, 8.5.2 дох	01-11 сард	<p>“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийг хэрэгжилтийг хангаж, тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4, 8.5.2 дох заалтуудыг сумын веб сайтаар ил тод мэдээллэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ <b>8.4.4 дэх</b> заалтанд хамааралтай мэдээллийг оруулсан байдал <a href="http://shiveegovi.gs.gov.mn/category/127">http://shiveegovi.gs.gov.mn/category/127</a></li> <li>✓ <b>8.5.2 дах</b> заалтанд хамааралтай мэдээллийг ил тод мэдээллэсэн байдал <a href="http://shiveegovi.gs.gov.mn/news/513">http://shiveegovi.gs.gov.mn/news/513</a> <a href="http://shiveegovi.gs.gov.mn/news/514">http://shiveegovi.gs.gov.mn/news/514</a></li> </ul>	100

			олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	заалтуудыг ил тод мэдээллэх		<a href="http://shiveegovi.gs.gov.mn/news/515">http://shiveegovi.gs.gov.mn/news/515</a> <a href="http://shiveegovi.gs.gov.mn/news/516">http://shiveegovi.gs.gov.mn/news/516</a> <a href="http://shiveegovi.gs.gov.mn/news/517">http://shiveegovi.gs.gov.mn/news/517</a> <a href="http://shiveegovi.gs.gov.mn/news/519">http://shiveegovi.gs.gov.mn/news/519</a> <a href="http://shiveegovi.gs.gov.mn/news/520">http://shiveegovi.gs.gov.mn/news/520</a>	
8	Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	11	Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Нэмэгдсэн улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ га. талбай	01-11 сард	Сумын төвөөс баруун талд байрлах <b>“Бэлгэхийн улаан өндөр”</b> гэх тахилгатай уулыг оруулан ойр орчмын <b>2593 га</b> газрыг сумын ИТХ-ын 2023 оны 09 сарын 04-ний өдрийн “Орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай” 04 дүгээр тогтоолоор баталж орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна. Тус тогтоолыг 2024 он гарсны эхнээр Ашигт малтмал газрын тосны газарт албан бичгээр хүргүүлэн Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасны дагуу уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэгдээд байна.	100
9	Уул уурхайн улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээн, туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар бууруулна.	12	Уул уурхайн улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ. Туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар бууруулна.	Нөхөн сэргээх газрын хэмжээ-4 га Туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар бууруулсан байх	01-11 сард	2024 он гарснаар “Шивээ-овоо” ХК техникийн <b>нөхөн сэргээлтийг 05 дугаар сард 4 га талбайд</b> хийсэн бөгөөд биологийн нөхөн сэргээлтийг 06 дугаар сард хийхээр талбайг бэлтгэж байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний 06 дугаар тогтоолоор Байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах “Хоггүй сум” арга хэмжээний зардлаар <b>туурь хог хаягдалтай 5 га талбайг</b> цэвэрлэхээр 10 сая төгрөгний төсөв батлагдаад байгаа бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Тус ажил 06-07 дугаар сард хийгднэ.	100
10	Аймаг, сумдын төвд шинээр авто зам барьж, улсын чанартай авто замтай холбоно.	13	Аймаг, сумдын төвд шинээр авто зам барьж, улсын чанартай авто замтай холбоно.	Шивээговь сумыг Улсын чанартай авто замтай холбох 7 км авто замын ажлыг үргэлжлүүлэх	01-11 сард	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Шивээговь сумыг Улсын чанартай авто замтай холбох 7 км авто замын ажил 2024 оны 04 дүгээр сарын 20-ноос хийгдэж эхлээд байна. <b>/Шороо хусалт, үерийн далан гаргалт зэрэг ажлууд хийгдээд байна/</b>	50

11	“Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	14	“Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	Арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх Төлөвлөгөөний хэрэгжилт 100%	01-11 сард	“Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээний дагуу <b>2 зорилт 7 арга хэмжээ</b> тэй төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний дагуу 2024 он гарснаар: -Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа /нийтийг хамарсан ажил/-35 иргэн -Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг-2 -Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэг-2 -Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ.-2 -Малжуулах арга хэмжээ-3 төсөл тус тус хүлээж авсан байна. Төслийг 06 дугаар сард шалгаруулахаар ажиллаж байна. <b>Төлөвлөгөөний хэрэгжилт 50%-тай.</b>	50
12	Ерөнхий боловсролын сургуулиудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ. /Шивээговь сумын ЕБС, Сүмбэр сумын 2, 5, 1-р сургуулиудын барилгын өргөтгөл/	15	Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулж, гадна талбайг тохижуулна.	Сургуулийн барилгын ажлын явц 100%	01-11 сард	Шинэ сургуулийн барилгын ажилд 2024 оны 3 сард <b>БШУЯ</b> болон бусад холбогдох газруудаас <b>хяналт шалгалт</b> хийгээд байна. Тус шалгалтаар Барилгын магадлагаа болон төсөвт өртөгийг дахин шинэчлэхээр болсон. Шийдвэрийн дагуу ажлыг гүйцэтгэгч “Говийн өгөөж” ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ажлыг хүлээлцэхээр гэрээг дахин шинээр байгуулаад байна.	-
13	Аймаг, сумдын төвийн камержуулалтын системийг шинэчлэн өргөтгөж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	16	Сумын төвийн камержуулалтын системийг шинэчлэн өргөтгөж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	Сумын төвийн камержуулалтын системийг шинэчлэн өргөтгөх Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал	01-11 сард	2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын ээлжит бус 26 дугаар хуралдаанаар 2024 онд <b>сумын төвд байрлуулсан хяналтын телекамерыг засварлах, шинээр нэмж суулгах, шилэн кабел татах</b> зэрэг ажлуудыг хийлгэхээр 19 сая төгрөгний санхүүжилттэй ажлын худалдан авах ажиллагаа зарлаад байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээний хүрээнд сумын Цагдаагийн хэсэг сумын төв болон босоо тэнхлэгийн авто зам дагуу 24/7 эргүүл шалгалтыг хийж, илэрсэн зөрчил хэрэгт холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.	70

14	Сумдад "Жишиг гудамж" төслийг хэрэгжүүлэн, тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	17	Шивээговь суманд "Жишиг гудамж" төслийг хэрэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	Шивээговь суманд "Жишиг гудамж" төслийг хэрэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	01-11 сард	Суманд "Жишиг гудамж" төслийг хэрэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил нь 2024 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд эрэмбэлэгдсэн боловч иргэдийн санал аваагүй тул хойшилсон. 2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтанд тусгагдсан бөгөөд иргэдийн санал авах ажил хуулийн хугацаанд явагдаж байна.	-
15	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтыг сайжруулж, гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлнэ.	18	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтыг сайжруулж, гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлнэ.	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл нэмэгдүүлэх	01-11 сард	2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор <b>Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажлын</b> төсвийг 160,000,000 төгрөгөөр баталсан. Сумын Засаг даргын 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 дугаар захирамжаар "Үнэлгээний хороо"-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. 2024 оны 04 дүгээр сарын 08, 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр техникийн тодорхойлолтыг батлуулж, нээлттэй тендерийг цахим сайтад 2 удаа зарласан. Тендерт оролцогч оролцоогүй тул тендерийг дахин зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулахаар ажиллаж байна.	70
16	Тусгай зориулалтын онгоц хөөрч буух газрын асуудлыг шийдвэрлэж, арчлалт хамгаалалтыг хийнэ.	19	Тусгай зориулалтын онгоц хөөрч буух газрын асуудлыг шийдвэрлэж, арчлалт хамгаалалтыг хийнэ.	Тусгай зориулалтын онгоц хөөрч буух талбайн арчлалт хамгаалалтыг хийнэ.	01-11 сард	Тусгай зориулалтын онгоц хөөрч буух газрыг сумын ИТХ-аар 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 04 дугаар тогтоолоор хэлэлцэж баталсан. Нисдэг тэрэгний хөөрөх, буух талбайг Шивээговь сумын Наадмын талбайн урд нисэх, буух зурвасын зориулалтаар X=316369.36 Y=5106134.36 X=316369.36 Y=5106084.36 X=316419.36 Y=5106084.36 X=316419.36 Y=5106134.36 координатад байгуулахаар баталсан. <b>Тусгай зориулалтын онгоц хөөрч буух газрын асуудлыг шийдвэрлэж, талбайн арчлалт хамгаалалтыг хийн ажиллаж байна.</b>	100

17	Цэцэрлэгийн барилгуудыг өргөтгөж, шинээр барина. /3 болон 5 дугаар цэцэрлэг/	20	Цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, шинээр барих ажлыг үргэлжлүүлэх	150-200 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын ажлыг хүлээн авах	01-11 сард	Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг “Монничко” ХХК хийж гүйцэтгэж байна. Барилгын ажил үе шатны ажлын хуваарийн дагуу цутгалт дүүргэлтийн ажил, барилгын дээврийн ажил, цахилгааны шугам дүүргэлт, хаалга, цонх хийх ажлууд хийгдэж байна. <b>Барилгын ажлын гүйцэтгэл 80%</b> . 2024 оны 09 дүгээр сарын 01-нд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.	80
18	Багийн Засаг дарга нарын үйл ажиллагааг сайжруулах, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх	21	Багийн дарга нар чадавхуулах сургалтад хамрагдах	Чадавхжуулах сургалтад хамрагдсан тоо	01-11 сард	Багийн Засаг дарга нарын үйл ажиллагааг сайжруулах, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд: ❖ Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр, 01 дүгээр сарын 25-ны өдөр болон 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад хамрагдсан. ❖ 2024 оны 3-р сарын 21-24, 4-р сарын 25-26-ны өдрүүдэд Улаанбаатар хотод Удирдлагын академид “Иргэн төвтэй хөгжилд засаг захиргааны анхан шатны нэгжийн удирдлагын оролцоо” сэдэвт Олон улсын форумд бүх аймаг сумын багийн Засаг дарга нар хамрагдан, Удирдлагын академиас Сертификат олгоод байна. ❖ Аймгийн Боржигон чуулгад 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас баталсан “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Нийгмийн даатгалын багц хууль”-ийг сурталчлан таниулах нөлөөллийн арга хэмжээнд оролцоод байна. <b>Сургалтад хамрагдсан тоо -6</b>	100
19	Сумын төвийн тохижилтыг сайжруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө	22	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	01-11 сард	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: ➢ Сумын төсвийн 5 албан байгууллага “Хог хаягдлын менежмент”-ийн төлөвлөгөөг гарган, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. ➢ АБ, ААНэгж бүр гадна талбайдаа хог хаягдал ангилан ялгах зориулалтын савтай болох, айл өрх бүр хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахивар авах цэгтэй болох	

	боловсруулан, хэрэгжүүлэх					<p>ажлуудыг хийхээр ажиллаж байна. Дахивар бүтээгдэхүүн авах ангилан ялгаж эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилгоор сумын 1 иргэн Хоршоо хөгжүүлэх сангаас 65 сая төгрөгний зээл 2023 онд авсан бөгөөд үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар <b>хуванцар сав 2тонн, пивоны лааз 500кг, гялгар уут 180 кг дахивар</b> цуглуулсан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Сумын нийтийн эзэмшил газрыг тогтмол цэвэрлүүлэхээр 1 иргэнтэй <b>гэрээ</b> байгуулан цэвэрлэгээг тогтмол хийлгэж байна.</li> <li>➤ Бүх нийтийн их цэвэрлэгээг эхний хагас жилийн байдлаар <b>5 удаа</b> зохион байгуулаад байна. Тус цэвэрлэгээнүүдээр <b>нийт 16.5 тн хог</b> хаягдлыг төв хогийн цэгт булж, тэгшлэх ажил хийгдээд байна.</li> <li>➤ Сумын хэмжээний бүх төвлөрсөн хогийн пункер, хог хаях хашаа зэргийг буулгаж, зөвхөн хуваарийн дагуу хогны машинд ачиж хаях ажлыг 2 дох жилдээ хэрэгжүүлээд байна.</li> <li>➤ Нийгмийн хариуцлагын хүрээнд “Шивээ Сервис” ХХК, “Цотан Жанжин транс” ХХК нартай <b>Хог хаягдлын гэрээг</b> 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр байгуулан, хамтран ажиллаад байна.</li> </ul> <p><b>Эхний хагас жилээр төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай.</b></p>	100
20	Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх	23	ХХС-аар дэмжлэг үзүүлэх ХХС-аар зээл авсан биенес эрхлэгчдийн эргэн төлөлтийг хугацаанд нь хийлгэх	ХХС-аар дэмжлэг үзүүлсэн тоо ХХС-аар зээл авсан биенес эрхлэгчдийн эргэн төлөлтийн хувь	01-11 сард	<p>2024 оны эхний хагас жилийн байдлаар Хоршоо Хөгжүүлэх сангаас <b>зээл хүсэх хүсэлт ирээгүй</b> байгаа бөгөөд 2024 он гарснаар ХХС-ийн муу зээлийн ангилалтай хугацаа хэтэрсэн 20 зээлдэгчийн зээлийг төлүүлэх, сангийн хөрөнгийг бүрдүүлэх тал дээр хууль хүчний байгууллагуудтай хамтран ажиллаж 7 зээлдэгчийн үлдэгдэлтэй болтол бууруулаад байна. Тус 7 зээлдэгчийн хувьд 1 хүний зээл эргэн төлөгдөх боломжгүйгээр хаагдаж, 2 зээлдэгчийг улс орон даяар эрэн сурвалжлуулж, 4 зээлдэгчийг албадан төлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.</p> <p>Зээлийн эргэн төлөлтийн хувьд өнгөрсөн оны хугацаа хэтэрсэн зээл 65 хувийн биелэлттэй, хэвийн төлөлттэй зээлийн хувьд <b>эргэн төлөлт 112 хувь</b> буюу давсан биелэлттэй байна.</p>	100

21	Төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, иргэдэд төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай хүргэх.	24	Ёс зүй, харилцаа, хандлагаар сургалт авч, албан хаагчдыг чадавхжуулах Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, тасралтгүй хүргэхэд анхаарах	Ёс зүй, харилцаа, хандлагаар сургалт авсан тоо Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, тасралтгүй хүргэхэд анхаарсан байдал	01-11 сард	2024 он гарснаар Засаг даргын Тамгын газарт шинээр томилогдсон албан хаагчид болон бусад албан хаагчдад Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн <b>“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай”</b> хуулийг сурталчлан таниулж, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбарт байршуулаад байна. 2024 оны “Дотоод эрх зүйн сургалт”-ын төлөвлөгөөг 14 арга хэмжээтэйгээр төлөвлөж, төлөвлөгөөний дагуу 2024 оны 03 дугаар сард Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага сэдвээр аймгийн Шүүхийн Тамгын газрын даргаас сургалт авч, <b>13 албан хаагч</b> хамрагдсан. Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, тасралтгүй хүргэх ажлын хүрээнд <b>e-mongolia</b> системийн үйл ажиллагааг жигдрүүлэн, цахимаар гарах лавлагаа тодорхойлолтыг иргэдэд байнга гарган өгч ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 06 дугаар сард багтаан <b>ХУР-ДАН</b> системийн <b>КИОСК</b> машиныг сумын ЗДТГ-т байршуулахаар ажиллаж байна. Ёс зүй, харилцаа, хандлагаар сургалт авсан тоо-1	100
22	Байгууллагын бүтэц, орон тоог хууль, тогтоомжийн хүрээнд тогтоож, хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох мэдээ, мэдээллийг ил тод байршуулах	25	Байгууллагын бүтэц орон тоог хууль тогтоомжийн хүрээнд батлах Бүтэц орон тооны мэдээллийг ил тод байршуулах	Байгууллагын бүтэц орон тоог хууль тогтоомжийн хүрээнд батлах Бүтэц орон тооны мэдээллийг ил тод байршуулах	01-11 сард	Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн <b>A/01 дугаар</b> тушаалын дагуу сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоо, цалин санг баталж, сумын <b>цахим сайтад</b> ил тод байршуулсан байна. <a href="http://shiveeqovi.gs.gov.mn/content/2017">http://shiveeqovi.gs.gov.mn/content/2017</a>	100
23	Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэх, баяжуулах	26	ТАХ-ийн хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангуулах	ТАХ-ийн хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангуулсан тоо ТАХ-ийн хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангуулсан хувь	01-11 сард	Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу ЗДТГ-ын <b>14 албан хаагчдын</b> хувийн хэргийг бүрдүүлж, тухай бүр баяжуулалтыг хийж ажиллаж байна. Мөн Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тогтоол, Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт	100

						тавих ажил аймагт 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан бөгөөд тус ажлын дагуу сумын ЗДТГ-ын албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хянуулан, <b>зөрчил дутагдал гараагүй</b> байна. <b>ТАХ-ийн хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангуулсан албан хаагчдын тоо-14</b> <b>ТАХ-ийн хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангуулсан хувь-100%</b>		
24	Төрийн байгууллагын дотоод удирдлагын системийн ашиглалтыг дээшлүүлэх	ERP	27	ERP систем ашиглалтыг нэмэгдүүлэх	ERP систем шинээр ашиглалтад орсон тоо ERP системийг ашиглаж байгаа албан хаагчдын тоо	01-11 сард	Төрийн үйл ажиллагааны дотоод удирдлагын ERP системийг Засаг даргын Тамгын газрын <b>19 албан хаагчид</b> нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байна. ERP системээр ЗДТГ-т 2024 оны 5-р сарын байдлаар <b>182 албан бичгийг хүлээн авч</b> бүртгэл хөтлөн, шийдвэрлэн ажилласан. ЗДТГ-аас <b>гадагшаа</b> , бусад албан байгууллагууд руу цахим системээр <b>62</b> албан бичгийг илгээсэн байна.	<b>100</b>
<b>Дундаж биелэлт</b>								<b>92.5</b>

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН

МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ